



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 11/334

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 246 дүгээр
цэцэрлэгийн хөрөнгийг данснаас
дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 1,902,900 (нэг сая есөн зуун хоёр мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Чингэлтэй дүүргийн 246 дугаар цэцэрлэг (Я.Саранчимэг)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 246 дугаар цэцэрлэг (Я.Саранчимэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000967



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 434 дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 246 дугаар цэцэрлэг

Д/д	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтанд орсон огноо	Ашигласан жил	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр		
								Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс	
1	Биеийн өндөр жин хэмжигч	Хятад	2020.06.30	1	сайн	ш	1	280,500.00	280,500.00	-	-	Бусад хангамжийн материалын данс	Машин, тоног төхөөрөмж	
2	Зөөврийн кварцын гэрэл	Хятад	2020.06.30	1	сайн	ш	1	170,500.00	170,500.00	-	-	Бусад хангамжийн материалын данс	Машин, тоног төхөөрөмж	
3	Хүчилтөрөгийн аппарат комтейлерийн хамт	Хятад	2020.06.30	1	сайн	ш	1	990,000.00	990,000.00	-	-	Бусад хангамжийн материалын данс	Машин, тоног төхөөрөмж	
4	Камер /дотор 2ш/	Хятад	2020.09.18	1	сайн	ш	2	145,450.00	290,900.00	-	-	Бусад хангамжийн материалын данс	Машин, тоног төхөөрөмж	
5	Камер /гадна 1ш/	Хятад	2020.09.18	1	сайн	ш	1	171,000.00	171,000.00	-	-	Бусад хангамжийн материалын данс	Машин, тоног төхөөрөмж	
								1,902,900.00	1,902,900.00	-	-			
Бусад хангамжийн материалын дүн								6						
Нийт хөрөнгийн дүн								6						